

**“ДИСПЕТЧЕРИЙН ҮНДСЭНИЙ ТӨВ” ХХК-ИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛЭЭС**

2017 оны 12 дугаар сарын 12 өдөр

№ 08

Улаанбаатар хот

“Диспетчерийн үндэсний төв” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн хурлын тэмдэглэлд:

**ХЭЛЭЛЦСЭН НЬ:**

2017-2018 оны өвлийн их ачааллын горим төлөвлөлт, горимын тооцооны үр дүнгийн тухай

**ТЭМДЭГЛЭСЭН НЬ:**

.... Төвийн бүсийн нэгдсэн сүлжээний 2017-2018 оны өвлийн их ачааллын горимд цахилгаан эрчим хүчний хэрэглээ (түгээлтээр) 3673.96 сая кВт цаг буюу 2016-2017 оны өвлийн горимын гүйцэтгэлээс 2,8 % буюу 100.7 сая кВт цагийн өсөлттэй байхаар төлөвлөгдсөн.

Өвлийн горимын үеийн системийн оргил ачаалал 12 дугаар сард  $P_{\max}=1005$  МВт, бага ачаалал 9 дүгээр сард  $P_{\min}=440$  МВт байхаар төлөвлөв.

Дулааны сүлжээнд хийх чанарын тохируулгыг эх үүсвэрүүд дээр төвлөрсөн дулаан хангамжийн дүрмийн 2.2.3.4 заалтын дагуу тухайн орон нутгийн цаг агаартай уялдуулан тооцож өгсөн температурын графикийг мөрдөж ажиллана.

2017-2018 оны халаалтын улиралд жишмэл түлшний зарцуулалт нь өмнөх оны мөн үеийн гүйцэтгэлээс 3.7% өсөлттэй байхаар төлөвлөгдөж байна.

Оргил ачааллын үеийн тооцоонд хүчдлийн түвшинг өргөх арга хэмжээг авч зарим дэд станцуудын реакторуудыг бэлтгэлд шилжүүлсэн болно... гэж тэмдэглэжээ.

**ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:**

**Компанийн гүйцэтгэх захирал Д.Балдорж, Тэргүүн дэд захирал бөгөөд ерөнхий диспетчер Л.Бөхболд нарт үүрэг болгох нь:**

1. “Төвийн бүсийн нэгдсэн сүлжээний 2016-2017 оны өвлийн их ачааллын үеийн горим”-ыг мөрдөх,

2. Нүүрс хэмнэлтийн горим, аваарийн болон онцгой үеийн горимыг боловсруулан мөрдөх,

3. Батлагдсан горимыг мөрдлөг болгон нэгдсэн системийг өдөр тутмын горимыг зохицуулан ажиллах,

4. Өвлийн их ачааллын үеэр нэгдсэн системд ачаалал нэмэгдэхэд реле хамгаалалт, автоматикийн шаардлагатай тоноглолуудыг шалгах, найдвартай тасралтгүй ажиллагааг хангахад хамтран ажиллах талаар ЦДҮС ХК-нд албан бичиг хүргүүлэх,

5. Нэгдсэн сүлжээнд холбогдох эх үүсвэрүүдийн техник эдийн засгийн үзүүлэлтийг ЭХЯ-ны шинжлэх ухаан техникийн зөвлөлийн хурлаар батлахдаа горимын тооцоог Диспетчерийн үндэсний төвөөр гүйцэтгүүлж байх шийдвэрийг төрийн захиргааны төв байгууллагаар гаргуулах талаар санал тавьж шийдүүлэхийг үүрэг болгох... гэжээ”.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.БАЛДОРЖ